

БАТЛАВ.  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Н.ЦЭРЭНБАТ

БАТЛАВ.  
САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

## ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

#### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улс НҮБ-ын Биологийн олон янз байдлын тухай конвенцид 1992 оны 6 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурж, Улсын Их Хурал 1993 оны 6 дугаар сарын 1-ний өдөр соёрхон баталсан.

2010 оны Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Талуудын 10 дугаар бага хурлаас генетик нөөцийг хамгаалах, түүнийг ашигласнаас үүсэх үр шимиийг шударгаар хүртээх зорилгоор Генетик нөөцийн тухай Нагояагийн протоколыг баталсан бөгөөд Монгол Улс энэхүү протоколд 2012 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр гарын үсэг зурж, Улсын Их Хурал 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр соёрхон баталсан. Ингэснээр Монгол Улс генетик нөөцийг ашигласнаас үүдэх үр шимиийг шударгаар хүртээх, хуваарилах чиглэлээр тодорхой үүрэг хариуцлагыг олон улсын өмнө хүлээсэн.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.3.3.1-д “Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална” гэж, 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.5.3.5-д “Нэн ховор, ховор амьтан, ургамал болон бичил биетний омог, эд, эсийн өсгөврийн сан байгуулна” гэж, 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлого”-ын 3.2.5-д “Генетик нөөц, түүнтэй холбогдох уламжлалт мэдлэгийг бүртгэж үнэлэх, ашиглах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, нөөцийн үр өгөөжийг хүртэх нөхцөлийг хангах” гэж, 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 3.27-д “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн генетик нөөцийг ашиглах, түүний өгөөжийг хүртэх эрх зүйн орчинг бүрдүүлэх” гэж, 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.8.2-т “Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, үндэсний чадавхийг бэхжүүлэх” гэж тус тус заасан нь Генетик нөөцийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

#### 1.2.Практик шаардлага

Дэлхий нийтэд хэрэглэж байгаа ихэнх эм, биобэлдмэл, хүнс, гоо сайхны бүтээгдэхүүн нь байгалийн гаралтай буюу генетик нөөцөөс гарган авсан эсхүл түүнээс санаа авч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүд байдаг.

Монгол орны эрс тэс уур амьсгалд дасан зохицсон биологийн нөөц баялаг нь бидний ашиглаж болох үнэ цэнэ бүхий генетик нөөцийг агуулж байдаг. Гэвч одоогийн байдлаар биотехнологийн шинжлэх ухаан дорвитой хөгжөөгүйгээс эдгээр генетик нөөцийг хангалттай хэмжээнд судалж тогтоогоогүй, генетик нөөцийг бүртгээгүй, генетик нөөц болон уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүсэх үр шимийг шударгаар хүртээх эрх зүйн тогтолцоо бий болоогүй, хүний нөөцийн чадавх бүрдээгүй байна.

Биологийн нөөцийн хувьд Монгол орны ургамлын аймагт нийт 7315 зүйл бүртгэгдээд байна. Эдгээрээс нэн ховор ургамлын 133 зүйл, ховор ургамлын 355 зүйл, эндемик буюу унаган ургамлын 120 зүйл байна.

Монголын орны ургамлын улаан дансны бүртгэлд байгаа нэн ховор, ховор зүйл ургамлыг олон улсын жишгийн дагуу үнэлгээ хийхэд амьдрах орчны дарамт, хэт ашиглалтын улмаас ургамлын зүйлийн 11% устаж байгаа, 26% устаж болзошгүй, 37% эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр, 15 хувь ховордож болзошгүй байгааг тогтоосон байна.<sup>1</sup>

Монгол Улсад бүртгэгдсэн 3160 зүйл гуурст дээд ургамлын 100 орчим зүйл ургамлыг эмийн зорилгоор түгээмэл хэрэглэж, 200 орчим зүйл ургамлыг эмийн үйлдвэрлэлд, 200 орчим зүйлийг цайнд, 50 орчим зүйлийг хүнсэнд, 100 орчим зүйл ургамлыг малын тэжээлд ашиглаж байна.<sup>2</sup>

Монгол орны амьтны аймгийн хувьд өөр хоорондоо ялгаатай олон янзын экосистемд дасан зохицсон 141 зүйл хөхтөн, 486 зүйл шувуу, 22 зүйл мөлхөгч, 6 зүйл хоёр нутагтан, 74 зүйл загас, 13000 зүйл шавьж бүртгэгдээд байна. Эдгээрийн 32 зүйл нэн ховор, 76 зүйл ховор амьтан байна.

Монгол орны амьтдыг олон улсын ховордлын зэргийн шалгуур үзүүлэлтээр үнэлж үзэхэд загасны 2% устаж байгаа, 13% нь устаж болзошгүй, 8% нь эмзэг, хоёр нутагтны 67% нь эмзэг, мөлхөгчдийн 11% нь эмзэг, 28% нь ховордож болзошгүй, шувууны 10% нь (устаж байгаа 0.6%, устаж болзошгүй 1.7%, эмзэг 3.3%) ховордсон, 4.4% нь ховордож болзошгүй зэрэглэлд багтсан байна. Хөхтний 1% нь байгальд устсан, 2% нь устаж байгаа, 11% нь ховордож байгаа, 3% нь эмзэг, 6% нь ховордож болзошгүй зэрэглэлд багтсан байна.<sup>3</sup>

Ургамал, амьтны зүйлийн ховордлын үндсэн шалтгаан нь хууль бус ашиглалт, хүний болон байгалийн хүчин зүйлийн нөлөөтэй амьдрах орчны хомсдол доройтлоос үүдэлтэй байна. Энэ нь биологийн буюу генетикийн нөөц баялгаа хуулиар хамгаалах, нөхөн сэргээх нь зайлшгүй шаардлагатай болохыг харуулж байна.

Монголын ард түмэн байгаль хамгаалах, түүнтэй зохицон амьдарч үр шимийг зохистой ашиглаж ирсэн арвин баялаг уламжлалт мэдлэг, соёлтой болохын баталгаа нь өвөрмөц, эмзэг тогтоцтой экосистемүүдээ харьцангуй унаган төрхөөр нь өнөөг хүртэл хадгалж, хамгаалж ирсэн явдал юм. Уламжлалт мэдлэгээ ахуй соёлдоо шингээж өвлүүлж ирж чадсан цөөхөн ард түмний хувьд энэ байдлаа баталгаажуулах, хуулиар хамгаалах тогтолцоог бий болгох нь уламжлалт мэдлэгээ үеэс үед тасралтгүй үлдээх нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.<sup>4</sup>

<sup>1</sup> Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2015-2016 он. БОАЖЯ. Улаанбаатар 2017, 149-р хуудас

<sup>2</sup> Володя Ц, Д.Цэрэнбалжир, Ц.Ламжав. Монгол орны эмийн ургамал. Улаанбаатар, 2010. ISBN код: 978-99929-0-431-2

<sup>3</sup> Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан. 2015-2016 он. БОАЖЯ. Улаанбаатар 2017, 164-р хуудас

<sup>4</sup> Sh.Bold. Medical Research Institute, Ministry of Health Mongolia. Brief History and Development of Traditional Mongolian Medicine. World Intellectual Property Organisation's paper. Accessible through: [http://www.wipo.int/edocs/mdocs/tk/en/wipo\\_ipatk\\_bkk\\_09/wipo\\_ipatk\\_bkk\\_09\\_topic6\\_1.pdf](http://www.wipo.int/edocs/mdocs/tk/en/wipo_ipatk_bkk_09/wipo_ipatk_bkk_09_topic6_1.pdf)

Жишээ дурдвал судалгаагаар хачигны Зүүн хойт Азийн, Азийн болон баруун Европын гэсэн гурван хэв шинжийн вирус байдгийг тогтоожээ. Гэтэл Монголоос энэ гурван хэв шинжийг агуулсан вирус олдсон байна. Энэ бол байгаль эхийн бүтээсэн вакцин бөгөөд энэ гурван шинжийн вирусын өвчлөлөөс бүрэн хамгаалах чадвартай үнэ цэнэтэй бүтээгдэхүүн гарган авч чадвал, эдийн засгийн үр шим, ашгийг нь бид цаашид тогтвортой хүртэх боломжтой юм.

Монгол орны зарим зүйл ургамлыг эмийн болон бусад зорилгоор экспортод гаргаж байна. Тухайлбал, чихэр өвснөөс Япон улс хорт хавдрын эсрэг эм, дэрэвгэр жиргэрүүгээс Хятад улс шувууны ханиадны эсрэг эм, хусны онгол, тургуу мөөгнөөс Солонгос улс хавдрын эсрэг эмийг үйлдвэрлэн дэлхийн зах зээл дээр борлуулж, үлэмж хэмжээний ашиг олсон байх боломжтой юм. Үүнээс манай улс гарал үүслийн орны хувьд үр шим хүртэж чадахгүй байна.

Монгол орны генетик нөөцийн асуудал нь биологийн нөөцийг хамгаалах төдийгөөр хязгаарлагдаж, байгаль дээрээс хувь хүн, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага генетик нөөцийг ямар ч хяналтгүйгээр олж цуглуулдаг, зөвшөөрөлгүйгээр судалдаг, ашиг хуваах, хүртээх талаар гэрээ байгуулдаггүй болон өөрийн орны генетик нөөцөө судалж, тодорхойлж, тогтоож чадахгүй байгаа зэргээс гадаад улс руу алдаж байна.

Тухайлбал, 2012-2017 оны байдлаар Монгол Улсын хилээр экспортод гаргасан ургамал, амьтан, бичил биетний гаралтай зүйлүүдийг гаалийн бүрдүүлэлтэд өгсөн мэдүүлгээс судалж үзэхэд давхардсан код, нэрээр нийт 1450 орчим удаа хилээр гаргах зөвшөөрөл олгосон байна.<sup>5</sup> Улсын хилээр гарч байгаа ургамал, амьтан, бичил биетний эдийн засгийн ач холбогдол нь олон сая ам.доллараар хэмжигдэх бололцоотой бөгөөд өдгээр генетик нөөцийг ашиглан ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэж худалдаанд гаргаж байгааг бүрэн тооцох боломжгүй байна.

Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг гадаад улс орнууд хэрхэн зохицуулж байгааг судалж үзэхэд Австрали улс гадаад, дотоодын аж ахуйн нэгжид 2011 оноос 200 гаруй зөвшөөрөл өгсний 3 зөвшөөрөл нь арилжааны зорилготой хийгдсэн бөгөөд тус улс генетик нөөц, уламжлалт мэдлэгийг ашиглан бизнесийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах бодлого барин ажиллаж байна.

Дэлхийн эм зүйн салбар 2011 онд 955,5 тэрбум ам долларын орлого олсны дийлэнх хувийг Хойд америк, Европ болон Япон улсууд эзэлж байна. Бразил, Энэтхэг, Хятад улсын эмийн салбар 2016 оны байдлаар 20 хувиар өссөн байна. 2016 оны байдлаар дэлхийн эм зүйн салбарыг нэгтгэн үзвэл 1.2 их наяд ам долларын орлого олсон байх тооцоо хийгдсэн байна.<sup>6</sup>

Энэтхэг улс 2015-2016 оны байдлаар "улаан мод" буюу (Red Sanders wood)-г ашигласны үр шимийг 5 хувиар тооцож, 165.1 сая рупи орлого олсон байна. Уг модыг тавилга, хими болон анагаах ухааны чиглэлийн түүхий эдэд ашигладаг байна.<sup>7</sup>

Эдгээр жишээнээс харахад Монгол Улс генетик нөөц, уламжлалт мэдлэгээ хуулиар хамгаалж, хөгжүүлж, зохистой ашиглуулж чадвал гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олсон ашиг орлогоос хувь, ногдол авах боломж, нөхцөл нээгдэхээр байна.

Аливаа генетик материалыг урт хугацаанд стандартын шаардлага хангасан нөхцөлд цуглуулж, хадгалах, хамгаалах зориулалттай дэд бүтэц, бүртгэл, мэдээллийн сан, мэргэшсэн ажилтнууд бүхий үндэсний хэмжээний нэгдсэн генийн сан байгуулах бодит шаардлага байна. Генийн санг байгуулснаар үндэсний хэмжээнд генетикийн нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаарх бүхий

<sup>5</sup> Гаалийн ерөнхий газрын 2012-2017 оны статистик мэдээ

<sup>6</sup> Bioscience at a Crossroads: The Pharmaceutical Industry:

<https://www.cbd.int/abs/resources/factsheets.shtml#ABSinfokit>

<sup>7</sup> ABC fact sheet 2016. The National Biodiversity Authority. India

л мэдээллийг хадгалах, хамгаалах улмаар түүнтэй холбоотой үр шим, ашгийг нэмэгдүүлэх, судалгаа шинжилгээний зорилгоор инновацийг бий болгох бодит боломжууд гарч ирэх юм.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагыг үндэслэн Генетик нөөцийн тухай хуулийн төслийг боловсруулах шаардлага зүй ёсоор гарч байна.

Түүнчлэн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу судлагаа хийсэн ба хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарсан.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Генетик нөөцийн тухай хууль нь доор дурдсан харилцааг зохицуулна. Үүнд:

1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх амьтан, ургамал, бичил биетний гаралтай үнэ цэнэ бүхий генетик нөөц болон тэдгээртэй холбоотой уламжлалт мэдлэгийг судлах, бүртгэх, хадгалж хамгаалах, ашиглах, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, тэдгээрийн өмчлөлтэй холбоотой харилцааг зохицуулна.

2. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашигласнаас үүдэх үр шим, ашгийг шударга, эрх тэгш хүртээх, уламжлалт мэдлэгтэй холбоотойгоор иргэдийн эрх, ашгийг хамгаалах, холбогдох зөвшөөрлийн механизмыг бий болгох зэрэгтэй холбоотой зохицуулалтыг бүрдүүлнэ.

3. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгтэй холбогдох үйл ажиллагааг зохицуулах төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын эрх үүргийг тодорхой зааж өгнө.

4. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судлах, бүртгэх, хадгалж хамгаалах, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан бий болгох, үндэсний генийн сан байгуулах, түүнтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгана.

5. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглах, биологийн судалгаа, биохайгуул явуулах, генетик нөөцийг хилээр нэвтрүүлэхтэй холбоотой тусгай зөвшөөрөл авах, урьдчилсан мэдэгдэл, генетик нөөцийн эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үр шимийн гэрээ байгуулах харилцааг зохицуулна.

6. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны төлбөр тооцох, үр шимийг хүртээхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

7. Тайлан мэдээ гаргах, хууль зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага болон холбогдох харилцааг бусад хуулиудтай уялдуулан зохицуулахаар тусгана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авах арга хэмжээ**

Хуулийн төсөл батлагдсанаар экосистемийн тогтвортой байдлыг хадгалах, байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах үр дүнд хүрэх нөхцөл бүрдэнэ:

- Генетик нөөцийн биологийн судалгаа, биохайгуулын үр дүнд генетик нөөцийн үнэ цэнэ, биотехнологи дамжуулалт өсөн нэмэгдэж, улмаар үндэсний боловсон хүчний судалгаа шинжилгээ хийх, шинэ техник, технологи боловсруулж нэвтрүүлэх, инновацийн санал, санаачилга гаргах чадавх бүрэлдэн бий болж, генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигч болон хэрэглэгчийн хоорондох харилцаа зохицуулагдаж, ашиглалтаас бий болох үр шимийг Монгол Улс, эзэмшигчид хүртэх боломж бүрдэнэ.

- Монгол орны генетикийн нөөцийг үндэсний эрх ашигт нийцүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр ашиглаж болох боломжит

нөөц, даацын хүрээнд зохистой ашиглах, биологийн олон янз байдлын хамгаалал сайжирна.

- Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгт суурилсан биотехнологийн ололт амжилтанд тулгуурласан судалгаа-үйлдвэрлэл хөгжинө.

- Монгол орны генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн эрх зүйн орчин бий болсноор дотоод, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх, эм, гоо сайхан, биотехнологи, химийн болон бусад үйлдвэрлэл хөгжиж ажлын байр нэмэгдэнэ.

- Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээл дээр гаргах боломж бүрэлдсэнээр иргэн, хуулийн этгээдэд эдийн засгийн бодит эерэг үр дүнг бий болгоно.

- Генетикийн нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг эзэмшигчийн эрхийг хамгаалах, үр шим, өгөөж хүртээх, тэдгээртэй холбогдох үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн Хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаар**

Энэхүү хуультай холбогдуулан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулна.

---00---